



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 8/09

Цагаан-Уул сум

Г Иргэнд газар эзэмшүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны ээлжит XIV хуралдааны 09 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасны дагуу шинээр газар эзэмшиж байгаа 6 иргэний 0,6 га (6090м²) газрыг хавсралтад дурдсанаар эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (А.Энхбаатар), Улсын бүртгэгч (Д.Ичинхорлоо) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Сумын Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор сумын Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг Газрын даамал (А.Энхбаатар)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Г.Одгэрэл) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ

/Zahiramj 2024/